

Ц.Цолмон

Хоёр хөрштэйгөө
холбоотон байя

Д.Баярхүү

СССР нурахын өмнөх нөхцөл
дахин бүрдэж байна

Д.Уламбаяр

Солонгосын хойгийн хурцадмал
байдал: Асуудал ба шийдэл

БОДЛОГЫН МЭДЭЭ

POLICY NEWS

AD CURRAM ET COMMUNICO!

2017.12 №6



Бодлогын судалгааны төв
Монгол Улсын Их Сургууль
Олон Улсын Харилцаа,
Нийтийн Удирдлагын Сургууль

РЕДАКЦИЙН ЗУРВАС

01

СУРГУУЛИЙН МЭДЭЭ

02 “ШХАБ дахь Монгол Улсын гишүүнчлэлийн асуудал” сэдвээр судалгаа хийж байна.

Хоёр хөрштэйгөө холбоотон байя

ХӨРШ ОРНУУД

04 СССР нурахын өмнөх нөхцөл дахин бүрдэж байна

БҮС НУТАГТ

06 Солонгосын хойгийн хурцадмал байдал:
Асуудал ба шийдэл

ОЛОН УЛСАД

09 Өөртөө засан тогтнох эрх үү, сепаратизм үү?

ОНЦЛОХ СЭДЭВ


11 2018: A year of tenuous stability

Дугаарыг эрхлэн бэлтгэсэн:

Х.Бэхбат
Б.Индра

Эх бэлтгэгч:
Хэвлэсэн газар:

Х.Балдандорж
“Удам Соёл” ХХК



Эдүгээ хүн бүр л хуучин оноо тайлагнан үдэж, шинэ нь “шийртэйхэн” байгаасай хэмээн хүсэн хүлээж буй билээ. Манай дотоод амьдрал адармаатай үйл явдлаар дүүрэн өнгөрч, арван найман он ч дутахгүй хэмээн амлах хүн олон байна. Эдийн засгийн эерэг үзүүлэлтүүд нэмэгдэх авч ихээхэн донсолгоотой хэвээр, ард олны амьжиргаа сайжирч мэдэгдэхгүй, харин дургүйцэл нь зузаарах нигууртай гэгцгээнэ. Зузаарах гэснээс Үндсэн хуульд өөрчлөлт орж бас “зузаарах” биз ээ.

Дэлхий дахины тэнгэр бүрхэг бүүдгэрээр барахгүй, далдыг харж зөгнөгчдийхөөр бол мөдгүй аянга цахилгаан буух бололтойдог. Ямар ч атугай энэ дугаартаа олон улсын харилцаа, геополитикийн нэрт судлаач Жорж Фридманы “GPF”-д нийтлэгдсэн төсөөллийг эх хэл дээр нь хуулан уншигч олондоо хүргэх нь зүйтэй гэж бодов, болгооно буй заа.

Манай гадаад харилцааны хувьд элчин сайд нарын томилгоо “улс төржсөнөөс” өөр “гавьтай” юм болсонгүй. Харин салбарын шийдвэр гаргагчид, шинжээч, судлаач, сонирхогчдын дунд чимээ анир багатай нэгэн мэтгэлцээн явж буйг анзаарч болохоор болжээ. Энэ бол “Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад” жинхлэх, эсэх тухай асуудал юм. Манай Бодлогын судалгааны төв эл асуудлыг онилон нухацтай судалж, зөвлөмж гаргах зорилгоор нэгэн төсөл хэрэгжүүлж эхлээд байна. Жинхлэх болсон, болоогүй гэсэн эсрэг тэсрэг байр суурийн аль нь давамгайлахыг одоогоор хэлэхэд бэрх аж. Энэ удаа “болсоны талын” нэг өгүүллийг нийтэллээ. Дараагийн дугаарт “болоогүйн талынхыг” нийтэлнэ. Уншигч Та ч бас санаа бодлоо хуваалцаж гэвэл бид дуртайяа хүлээн авах болно.

“Бодлогын мэдээ” бол үзэл бодол, санаа онооны харшилдан уралдах талбар бөгөөд зөвхөн чингэх замаар л бодлого чамбайрч, улам оновчтой болох нь ойлгомжтой. Энд нийтлэгдэж буй өгүүллүүд нь зөвхөн зохиогчдын өөрсдийнх нь юм шүү гэдгийг дахин санацгаая.

Таньд шинэ 2018 ондоо амжилт бүтээлээр арвин, эрүүл энх явахын өлзийтэй ерөөл дэвшүүлье!

Х.Бэхбат

* * *

If you want to know who controls you, look at who you are not allowed to criticize.
Voltaire

In general, the art of government consists of taking as much money as possible from one class of citizens to give to another.

Voltaire

Politics is too serious a matter to be left to the politicians.

Charles de Gaulle

“ШХАБ ДАХЬ МОНГОЛ УЛСЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН АСУУДАЛ” СЭДВЭЭР СУДАЛГАА ХИЙЖ БАЙНА.

Монгол Улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад (ШХАБ) 2004 онд ажиглагчаар орсноос хойш даруй 13 жил өнгөрчээ. Энэ хугацаанд тус байгууллагын анхдагч зорилго, шинж чанар, бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөж ирсэн бөгөөд үүнийг дагаад манай улс тус байгууллагад ажиглагч хэвээр байх уу, аль эсвэл гишүүн нь болж жинхлэх үү гэдэг асуулт удаа дараа гарч байлаа.

Олон улсын байдал, манай гадаад орчинд ч өөрчлөлт гарч өнөөдөр энэ асуулт тодорхой хариу нэхэж байгааг харгалзан ОУХНУС-ийн дэргэдэх БСТ уг асуудлыг тал бүрээс нь шинжин судалж бодлогын зөвлөмж гаргахаар шийдсэн юм. Судалгааны багийг туршлагатай ахмад дипломат, ОББЭЭС Ч.Баатар ахалж, др.проф. Н.Алтанцэцэг, др.С.Баясгалан зэрэг шинжээчид

оролцон ажиллаж байна. Энэ 12 дугаар сард мэргэжлийн хүмүүс, эрдэмтэн судлаачдыг оролцуулсан хэлэлцүүлгийг 2 ч удаа зохион байгуулаад байна. Судалгааны ажил 2018 оны 1 дүгээр сарын эцсээр дуусна. Явц байдал, үр дүнг нь “Бодлогын мэдээний” хуудсаар уншигч олондоо хүргэж байх болно.

Х.Бэхбат



Ц.Цолмон

Онц Бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд

ХОЁР ХӨРШТЭЙГӨӨ ХОЛБООТОН БАЙЯ

Монгол улс хоёрхон хөршөөр тойрон хүрээлэгдсэн, геополитикийн онцгой байршил бүхий өргөн уудам нутагтай, байгалийн их баялагтай, цөөн хүн амтай, дэлхийн бараг бүх улстай дипломат харилцаатай, аль ч улс оронтой газар нутгийн болон улс төрийн маргаангүй, НҮБ-ын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн, Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн АНУ, БНХАУ, ОХУ, Англи, Францаар цөмийн аюулгүй байдлын баталгаа гаргуулсан орон билээ. 90-ээд он хүртэл Монгол улс Зөвлөлт Холбоот Улс /Оросын Холбооны Улс/-тай холбоотон байсан. Сүүлийн хорь гаруй жил цэрэг-улс төрийн холбоотонгүй, хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах зарчмаар явж ирлээ. Гучаад жилийн өмнө зөвлөлтийн цэрэг Монголд

байрлаж Бээжинд ойроос цохилт өгөх чадавхийг бүрдүүлсэн байлаа. Тийм ч учраас Хятадууд Монголоос оросын цэргийг гаргах явдлыг Оростой харилцаагаа сайжруулах нэгэн нөхцөл болгон тавьж хэрэгжүүлсэн юм. Тэр үед мөн Монголыг Хятадад алдвал удахгүй Сибирийг алдах үүд нээгдэнэ гэж оросын судлаачид бичиж байсан. Эдгээр нөхцөл байдал нь Монгол улс хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харилцах бодлого явуулахад тааламжтай нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Хөрш гурван орон тэнцвэртэй, тогтвортой сайн харилцаатай байх нь ийнхүү гурвуулангийнх нь эрх ашигт нийцэж байгаа билээ.

Орчин үеийн олон улсын харилцааны жам ёсоор бид олон улс оронтой нээлттэй харилцаж байна. Монгол улс ардчилсан орон. Гадаад бодлогын хувьд

энэ нь гуравдах хөршийн үзэл баримтлалаар хэрэгжиж байгаа билээ. Орос Хятад хоёр хаяа залгасан анхдагч хөршүүд, хоёрдогч хөршүүд гэж хэнийг ч нэрлээгүй бөгөөд гуравдагч хөршүүд гээд бусад орныг хэлж байна. Бүс нутгийнхаа бүх улс оронтой найрсаг харилцаатай байдаг нь монголын өнөөгийн гадаад бодлогын чухал давуу тал юм. Энэхүү сайн хөршийн харилцаа нь зөвхөн хоёр талуудын харилцаанд төдийгүй бүс нутгийн хөгжилд хэрэгтэй давуу чанар юм.

Монголчууд бид гадаад бодлогодоо харгалзан үзэхүйц томоохон өөрчлөлтүүдтэй тулгарч байна. Нэгд, хоёр хөрш маань урьд өмнө хоорондоо зөрчилдөж байсан бол өнөөдөр холбоотон гэхээр ойр дотно харилцаж энэ нь ШХАБ, БРИКС-ийн бүтцүүдээр улам гүнзгийрч, хоёр талын бодит

төслүүдээр батжиж хэрэгжин удаан хугацаанд үргэлжлэх төлөвтэй байна. Хоёрт, ЗХУ болон Варшавын гэрээний цэргийн холбоо задарч АНУ хамгийн хүчтэй нь болж хятад, орос улсууд 20, 30 дугаарт эрэмбэлэгдэж байхад томъёолсон 30-аад жилийн өмнөх загварчиллаа бид хоёрдахь, гуравдахь хүчтэнүүд болсон анхдагч хөршүүдийнхээ бодит байдалтай уялдуулан өөрчлөх цаг болсон гэж үзэж байна. Гуравт, Орос-Монгол-Хятад гэсэн бүл, чандман хэлхээ, гурвалж, дэлхийн энэ хагаст бодитой оршиж байгаа геополитикийн тогтолцоо болж байгаа юм. Энэ бүл доторх Монгол улс нь ОХУ болон БНХАУ-ийн хувьд стратегийн хийгээд геополитикийн хувьд онцгой чухал орон. Орос Хятад улсууд хоорондоо сайн байвал бие бие рүүгээ хүрэх, нэвтрэх хамгийн дөт зам болно. Хятад Орос хоёр муудалцвал бие биений эмзэг цэгт хүрэх хамгийн дөт талбар билээ. Монгол нь Орос Хятад их гүрнүүд бие биендаа яагаад ч алдаж болохгүй улс төрийн тусгаар орон зай гэдгийг хаа хаанаа ойлгодог.

Хоёр талуудын харилцаа, гурван талт бүтэцээс гадна бүс нутгийн болон дэлхий нийтийг хамарсан олон улсын байгууллагуудын хүрэн дэх үйл ажиллагаа чухал болж байна.

Нэгэн зарчим дэвшүүлэе: Хоёр анхдагч хөрш орныхоо багтаж байгаа олон улсын байгууллага, олон талт ажиллагаанд гишүүнээр орж идэвхитэй ажиллах замаар монголын аюулгүй байдлыг улс төр- дипломатын аргаар хангахыг гадаад бодлогын тулгуур зарчим болгох нь зүйтэй гэж үзнэ.

Энэ зарчмыг хэрэгжүүлэн элсэн орвол зохилтой олон талт түншлэлийн нэг нь Шанхайн хамтын ажиллагааны байгууллага юм. ОХУ, БНХАУ, Казакстан, Тажикстан, Узбекистан, Киргиз, Энэтхэг, Пакистаныг багтаасан Шанхайн хамтын ажиллагааны байгууллага нь Төв Азид тогтвортой байдлыг бэхжүүлэх, оролцогч орнуудын нөхөрлөл, сайн хөршийн харилцааг хөгжүүлэх, улс төр, эдийн засаг, шинжлэх

ухаан болон бусад салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгыг тунхагласан бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны бүтэц юм. Терроризм, хэт даврагчидтай хийх тэмцэл, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрчим хүчний түншлэл ба соёлын салбарт хамтран ажиллахыг эрхэмлэн тунхагласан тус байгууллагаас хол хөндий байвал түүний тэргүүлэх чиглэл болсон тээврийн дэд бүтэц, эрчим хүч, телехолбоо, нефть, хийн салбар, ХАА, усны нөөцийн ашиглалтын томоохон төслүүдээс Монгол хоцроход хүрч байна. Манай орны ажиглагчын статус эхэн үедээ элсэх бэлтгэл үе гэж ойлгогдохоор байсан бол одоо элсэхгүйн тулд аргацааж байгаа, учраа олох гэж түдгэлзэж, үл итгэн тээнэгэлзэж байгаа хүмүүсийн араншин гэлтэй болоод байна. Хүрээлүүлэн байгаа анхдагч хоёр хөрштэйгөө олигтой итгэлцлийг бүрэлдүүлж чадахгүй бол тэд бидэнд итгэл өгч ирээдүйтэй төсөл, хамтын үйлстэй оролцуулахгүй хөндийрөх болно. ШХАБ бол эдийн засаг, нийгмийн хөгжлийн хувьд ч, аюулгүй байдал, цэрэг-улс төрийн үүднээс ч Монголд хэрэгтэй байгууллага учраас түүнд нэн даруй элсэх нь үндэсний эрх ашигт ництэй байх болно.

Хоёр талын харилцааны түвшинд аль нэг удирдагч болон нийгмийн хөдөлгөөнөөс шалтгаалсан алдаа эндэгдэл гарах боломж байсаар байдаг. Олон талт харилцаа нь хоёр талын харилцаанаас илүү алдаа эндэгдлээс хамгаалагдах давуу талтай юм. Цэдэнбалын үед ЗХУ-д нэгдэж тусгаар тогтнолоосоо татгалзаж, хүний нөмөрт амар хялбар хөгжих оролдлого гарсныг таслан зогсоход манай орны ОУ байгууллагуудын гишүүнчлэл шийдвэрлэх хориг үндэслэл, харагдахгүй хамгаалалт болсон гэж үзэж байна. Нөлөө бүхий ОУ-ын байгууллагын гишүүнчлэл ижил тэгш эрх олгож харилцан хамгаалалт болдог.

Манайхан тус нэгдлийн хүрээнд “эдийн засгийн хамтын ажиллагаа олигтой явахгүй байна” гэсэн таамаглал төдий дүгнэлтэд

хууртан ШХАБ-ын гадна суусаар “торгоны зам” болон эрчим хүч, зам, дэд бүтцийн ирээдүйтэй томоохон төслүүдийн гадна үлдэж энэ бүс нутаг дах “хар нүх” болж, “хөмөрсөн тогооныхоо” үлгэрийг давтах болоод байна. Энэ нь манай үндэсний эрх ашигт яавч нийцвэргүй юм.

ШХАБ нь АНУ, НАТО-той сөргөлдөх цэргийн блок болох гээд байна, хол байх хэрэгтэй гээд зарим хүмүүс их л сэтгэл зовнин бичих, ярих нь бий. Миний бодоход бид ШХАБ-ын гадна байх, дотор нь байхаас үл хамааран АНУ, НАТО өөрийн эрх ашгийг хамгаалчихна. Харин Монголын эрх ашиг, хувь зохиол хаана байгааг, хаашаа ойр байгааг ухаарах нь бидэнд чухал. ШХАБ цэргийн эвсэл боллоо ч түүнд элсвэл хоёр хөрштэйгөө хоюулантэй нь холбоотон болж аюулгүй байдал тусгаар тогтнол улам бүр баталгаажих юм. Улс орныхоо тусгаар тогтнол аюулгүй байдлыг улс төр- дипломатын аргаар хангахад цэрэг-улс төрийн олон талт зохимжтой холбоонд багтах явдал чухал ач холбогдолтой байх болно.

Монгол улс ШХАБ-д элссэнээр аль нэг орны эрх ашигт харшлах зүйлгүй бөгөөд Монголын ашиг сонирхолыг хүндэтгэдэг аливаа улс орон энэхүү гишүүнчлэлийг эсэргүүцэхгүй байх нь ойлгомжтой.

ШХАБ бол цөмийн зэвсэгтэй 4 гүрнийг багтаасан, дэлхийн хүн амын ихэнхи нь хамаарагдах, ямарваа нэгэн тэнэг тохиолдлоор дэлхийн дайн болдог юм гэхэд “ялах эвсэл” болохоор бэхжиж байна. Хятадын цэргийнхэн “дэлхийн аль ч өнцөг буланд болсон дайнд ялалт байгуулах чадвартай болно” гэж амлаж байгаа. Оросууд энэ зорилгыг өнөөдөр ч хийж чадах байх. Ялах хүчнээс зугтах хэрэг юу билээ. Ямарч байсан НАТО болон ШХАБ хоёрын сөргөлдөөний талбар болчихож болохгүй. Их Монгол Улсын эзлэн байсан газар нутаг ШХАБ-ын гишүүнчлэлд үндсэндээ хамаарагдаж байхад Монгол улс эндээс аль хир хол, аль хир удаан зугтах бол гэдгээ ч нэг бодоход илүүдэхгүй.



Д.Баярхүү

Олон улсын харилцааны судлаач-проф

СССР НУРАХЫН ӨМНӨХ НӨХЦӨЛ ДАХИН БҮРДЭЖ БАЙНА

Эдүгээгийн ОХУ өмнөх СССР-ийнхээ 1980-аад оны түүхэн нөхцөл байдалтай тун адилхан болж буй тухай гадаадын судлаачид бүү хэл оросын өөрийнх нь нэр хүндтэй эрхмүүд анхааруулж, тэмдэглэж, бүр ёрлож байгааг бид дэлхийн мэдээллийн сайтуудаас өлхөөн олоод үзчихэж болно. Бүр нэгэн дуугаар анхааруулж байна.

Эзэнт гүрэн, их гүрний оршин тогтнолын үндэс нь хүчирхэг эдийн засаг болохоос цэрэг зэвсэг биш гэгцгээх. СССР нуран нуртлаа цэрэг зэвсэг, стратегийн хүч нөөцөөр дутаж байгаагүй, харин ч бялхаж байсан. Тэглээ гээд перестройка, гласность гэдгийн гайгаар Орос ардчилагдах гэж байж бүр хөглөөд эдийн засгаа ор тас хаясан, БНУ-ууд Москвагаас нүүр буруулсан, үндэстэн-угсаатны далд нууц зөрчил ил гарч ирсэн.

Эдийн засаггүй хүчирхэг Орос гэж байхгүй гэдгийг хамгийн олон жил, амаа цангатай ухуулсан Путины найз, Сангийн сайд асан, одоо Стратегийн дүн шинжилгээний төвийн зөвлөлийн дарга, Иргэний санаачилгын хорооны дарга Алексей Кудрин 11 дүгээр сарын 25-нд Бүх Оросын иргэний форум дээр нүдэнд харагдаж гарт баригдтал хэлээд тавьчихлаа. Орос дахь эрх мэдлийн тогтолцоо эдийн засгийн

зорилтуудаасаа илэрхий хоцорлоо, төрийн удирдлагын түвшин эдийн засгийн адбиш зорилтуудаа шийдвэрлэх бололцоо олгохгүй байна, удирдлагын тогтолцоог солиод хийх ёстой ажлаасаа эхлэн хийе гэхчлэн ярьжээ.

Хөдөлмөрийн насны маш олон хүн үхэж үрэгддэг нь удирдлагын буруу тогтолцооноос болсон, дэлхий дээр хамгийн муу үзүүлэлттэй орнуудтай энэ үзүүлэлтээрээ зэрэгцлээ, энэ бол Оросын гамшиг сүйрэл, хүн ам өтөлж байна, эмнэлгийн тусламж хүрэлцэхгүй, архаг хууч өвчин дийлдэхгүй, Орос орон ядуурлын «шившигийн» түвшинд явж байна, ДНБ-ий түвшин ядуурлын түвшин хоёроо харьцуулбал ийм хэмжээнд байна – Энэбол өнөөгийн Кудрины үг мөн, бас 1980-аад оны II хагаст Горбачевын хэлдэг байсан үгс мөн.

Хямралаас өмнө ч таатай үеүд байсан гэлээ гээд Орос дахь ядуурлын түвшин өндөр байсан, хүн ам тутамд ногдох ийм өндөр ДНБ-тай улс орон ядууралтай байна гэдэг шившиг хэмээн Кудрин хэлжээ.

Зарим судалгаагаар Орос дахь аж амьдралын түвшний уналт сүүлийн гурван жил тасралтгүй үргэлжилж, тэр тоолонгоор ядуусын тоог өсгөжээ. Харин Кудрины хувьд ядуурлыг ядаж 4/1-ээр бууруулах тусгай бодлого, команд түүнд бий, зөвхөн Кремль

л үгийг нь авчих хэрэгтэй санж. Ямар үг вэ гэвэл Оросын төрт ёсны энэ цаг үед тун халтай байж мэдэхээр. Ерөнхийдөө 5-6 жилд ядуурлыг 4/1, 3/1-ээр бууруулна гэвэл төрийн албаны түшмэдийн тоог наанадаж 30 хувиар буулгах ёстой гэнэ. Төрийн ба бизнесийн удирдлагыг тоон технологийн аргад (цифровизация) шилжүүлж байж төрийн албаны их зардлыг хасна гэв. Ний нуугүй хэлэхэд Путины эрх мэдэл биет тулгуураасаа сална гэсэн үг юм, энэ нь.

Кудрин английн ВВС-д нэгэн ноцтой ярилцлага өгснийг олж үзлээ. Тэр тухай “Кудрин: перед Россией стоят те же риски, что привели к развалу СССР, <http://www.bbc.com/russian/>” сайт руу орж үзэж болно.

ЗХУ-тай нүүр тулж байсан тэдгээр эрсдэлүүд өнөөгийн Оросын өмнө тулгарлаа гэсэн байх юм. Оросын нөөцийг армид уу, эсвэл хүмүүнлэгийн салбарт уу гэдэг асуудлаар бөөн маргаан дагуулсан чуулга уулзалт дээр тэрээр тэр алдарт дүгнэлтээ хийжээ. Өнөөгийн Орос, тарж бутрахын өмнөх СССР хоёр яг параллель замаар явж байгаа мэт мэдрэгдэнэ, өнөөгийн Орост төвөөс зугтах, бүс нутагчлах үйл явцын эрсдэл тулгарлаа.

СССР-т арми, КГБ нь сулраад улс орон нурчихсан юм биш, эдийн засгийн үр ашиггүй, өөрийгөө зөвтгөх аргүй тэр загвар нь л СССР-ийг нураасан. Өнөөгийн Орост ч ялгаагүй үр бүтээлгүй эдийн засаг, тэргүүний технологи шингээх чадваргүй эдийн засаг гол эрсдэл болж байна.

СССР хэрэг дээрээ зэвсэглэлийн их ачаандаа өөрөө бүдэрч унасан. Зөвлөлтийн аж үйлдвэр нурсан, төлөвлөгөөт эдийн засаг сүйрсэнд нь либералууд, гайдарчууд буруугүй хэмээн тэрээр тун зоригтой дуугарчээ. Зөвлөлтийн тэр тостой үе алга болсны бурууг Гайдар ба түүний командад оросууд өнөөдөр ч тохсоор, зүхсээр ирснийг

Кудрин ийнхүү сөрснийг зөвөөс зөв хэмээн сайшаамаар.

Зэвсгийг хэтэртэл нь үйлдвэрлээд, тэр нь хэнд ч хэрэггүй үлдэж, тэгснээрээ Зөвлөлтийн эдийн засаг хөмрөх үндсэн шалтгаан болсон аж. Тэр их ган болд цувимал, цувималын үйлдвэрлэл зэвсэг үйлдвэрлэхэд хязгааргүй ажиллаж байсныг нэг удаагийн шийдвэрээр 5 дахин хорогдуулаад үзэхэд л бүхэл бүтэн хот, завод үйлдвэрүүд олноороо босоод ирж байжээ.

Бас нэг том гамшгийг Кудрин эргэж сануулжээ. Муж, орон нутгууд ба эдийн засгийн төлөвлөлтийн тогтолцоо хоёр тийшээ салж, СССР-ийг сүйдэлжээ. Тэгэхгүй гэвэл армийн шийдвэрлэх үүрэг гэгчийг арагш тавь, Орост эдийн засгийн цоо шинэ загвар төлөвшиж эхэллээ, түүгээрээ яв гэсэн байх юм. Орост цэрэг-дайны эрсдэл тулгараагүй байна, геополитикийн талбарт эсрэгцэл байгаа бол тэр нь тоглолт төдий юм. Хэрэв цэргийнхний үгээр үг хийвэл цааш улс орны нөөц хүч Оросыг цаашид авч явж чадахгүй, цэрэг-дайны эрсдэл доод түвшиндээ байна, хийрхэх хэрэггүй, Оросын ТВ-үүд өрнөдийн эсрэг хийрхлээ бүү дэвэргэ, тэгж дэвэргэсний гайгаар гадаадын технологиос хамааралтай Оросын бизнес, аж үйлдвэрт гай тарьж байна хэмээн Кудрин шүүмжилжээ.

Ийм шүүмжлэлийг сөрсөн мэт Оросын 2017-2019 оны улсын төсвийг ОХУ-ын Төрийн Дум хэлэлцэхдээ батлан хамгаалах зардлыг төсвийн нэг тэргүүлэх чиглэл болгож авч үзэн өндөр баталжээ. Улсын төсөвт боловсрол, эрүүлийг хамгаалах, эдийн засгийг дэмжих зардлыг хасч баталжээ.

ОХУ-д халтай байж мэдэх өөр буруу бодлогыг эдийн засгийн профессор Андрей Чернявский, Дарья Авдеева нар сануулж байна. Орост өрнийнхөн санц тавьсан биш, Оросын гадаад өр тоон

дүнгээрээ багассан боловч ДНБ дагалдан буурсан, дэлхийн зах зээлд эрчим хүчний түүхий эдийн үнэ унаснаас экспорт багассан, тэр хэрээр оросын дотоод хэрэглээ, хуримтлал зэрэг зэрэг буурсан гэнэ.

2016 оны эхний хагас жилийн байдлаар Оросын эдийн засаг гадаад өрийн дарамтаас болж муудсаар байсан, ДНБ-дээ ногдуулбал гадаад өр нь тэр үед 40 хувьд хүрсэн, 2014 онд 29 хувьтай байснаасаа огцом дорджээ. Одоо Оросын өр экспортоос олдог орлогынхоо 44 хувьтай тэнцэж байна. Хэрэв ийм өртэй яваад байх ахул Оросын эдийн засаг тэсч гарахгүй, сүйрнэ хэмээн хоёр профессор анхааруулж байна.

Оросын хуульч, өмгөөлөгч К.К.Фетисовын ярьснаар Орост үндэстэн-угсаатны зөрчил үлэмж хурцадсан, энэ хэрэгт буруутгагдаж байгаа иргэдийн 98 хувь нь оросууд байгаа нь бүр ноцтой баримт гэмээр. Үндэстэн-угсаатан зөрчилдөх шалтаг шалтгаан мундахгүй олон. Шашны зөрчил ч нэмэгдлээ. Лалын шашны хэт даврах, алан хядах үйл ажиллагаанд оросын иргэд олноороо татагдан орсон, хил давж хөлсний цэрэг болон Сири, Иракт очиж байлдсан, хөлсний хар ажил Орост эрхэлдэг тажик, чантуу, төв азийнхны дунд лалын шашны нөлөө их, элсэгдэх магадлал өндөр, тэр утгаар үндэстэн-угсаатны төдийгүй Оросын үндэсний аюулгүй байдалд ноцтой заналхийлэл учруулах хэмжээнд байна.

Үндэстэн-угсаатны зөрчил хурцадсан өөр нэг шалтгаан нь Оросын хөдөө тосгон эзгүйрч байгаа явдал аж. Доктор Татьяна Нефедовагийн судалгаа байна. Эдүгээ Оросын хотуудад хүн амьн 74 хувь аж төрж, үлдэх 26 хувь нь хөдөөнөө суурьшаар. Гэхдээ дотоодын миграцын урсгал шувтан саарсангүй үргэлжилжээ. Оросын сонгодог тосгоны мөхөл ХХ зууны сүүлчээс эхлээд эдүгээ

ид эрчээ авч байна. Оросын аль ч муж, БНУ-д очсон хөдөөнөөс хот руу дайждаг үзэгдлийг өлхөөн олж харж болох аж.

Үүнтэй холбогдуулан Гадаад хэргийн сайд С.Лавровын дээхнийн мэргэн үгийг эшлэе: Оросын эдийн засаг бэрхшээлтэй тулгарлаа. Гэхдээ уналт ганц Орост нүүрлээд байгаа юм биш. Гэсэн ч бид бууж өгөхгүй, үүнд итгэлтэй байж болно. Спортоос бусад салбарт бид АНУ-тай өрсөлдөхийг хүсэхгүй байна! Спортоос бусад салбарт гараа өргөлөө гэсэн үг аятай сонсдож байна.

Экс-Сангийн сайд А.Кудрин бас ингэж анхааруулж байсан, бүр 2014 онд. “Украины хямрал, мөн хөрөнгө оруулалтын шинэ загварт шилжихээс зайлсхийж байгаагаас шалтгаалаад Орос орон эдийн засгийн зогсонги байдалд орлоо. Оросын эдийн засгийн өсөлт ойрын гурван жилдээ лав 1 хувиас доошоо уруудах боллоо. Энэ хугацаанд Орос орон дэлхийн зах зээлээс шахагдан изоляцид орох аюул нүүрлэх нь гарцаагүй!”- энэ бүр ноцтой сануулга байв. Орост нэгэн зэрэг гурван хямрал нүүрлэснийг одоо хэрэгтэн болоод буй сайд асан А.Улюкаев ингэж ярьж байжээ. Олон салбарт зардал өссөн ба хэтэрсэн (1), ажил хэргийн тодорхой нэг цикл дууссан (2), геополитикийн нөхцөл байдал хурцдаж хориг, эсрэг хориг тавьсан (3) явдал гэжээ. Энэ гурван үйл явц нэгдэж нийлээд өнөөгийн хямралыг нөхцөлдүүлсэн ба буруутан нь оросууд өөрсдөө гэсэн байв. Энд дандаа иргэншсэн соёлжсон нөхдийн яриаг эшлэлээ. Тэгвэл иргэншээгүй соёлжоогүй нэг нөхөр дэлхийн III дайн эхэлж байгааг муу амлажээ. ЛДПР хэмээх нөлөө бүхий намын лидер Владимир Жириновский III дайн гарцаагүй гэхийн наагуур ярьсан байх юм. Энэ бүхнийг нийлүүлээд “СССР нурахын өмнөх нөхцөл бүрджээ” гэж дүгнэх үү? Таны бодол?



Д.Уламбаяр

ХИС-ийн ОУХНСС-ийн захирал

СОЛОНГОСЫН ХОЙГИЙН ХУРЦАДМАЛ БАЙДАЛ: АСУУДАЛ БА ШИЙДЭЛ

НҮБ-ЫН ШИНЭ ХОРИГ:

Өнгөрсөн 11 дүгээр сарын 29-нд Хойд Солонгос тив хоорондын Hwasong-15 баллистик пуужин туршсан учир 2017 оны 12 дугаар сарын 22-нд **НҮБ-ын АЗ-ын 2397 дугаар шинэ тогтоолыг** санал нэгтгэй батлав. Шинэ хоригоор газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг 90 хувиар танахаар болов. Ингэснээр жилд нийлүүлдэг 500 мянган баррель нефтийн түлш, дөрвөн сая баррель түүхий нефтийг хязгаарлана. НҮБ-ын гишүүн бүх улсад хөдөлмөр эрхэлж буй хойд солонгосын иргэдийг 24 сарын дотор нутаг буцаахаар хоригт заажээ.

Шинээр асуудал үүсч байгаа нь 9 дүгээр сард хийсэн «устөрөгчийн бөмбөг» гэх туршилтын улмаас хиймэл дагуулаас авсан зураглалаар хөрсний томоохон нуруул буй болж, Пүнгери туршилтын хонгилд нурах аюул үүссэн байх магадлалтай байгаа юм байна. Ингэвэл тэнд хуримтлагдсан цацраг идэвхит бодис гадагш гарах аюултай. Туршилт ойр ойрхон үргэлжилбэл туршилтын талбайгаас 114 км зайтай Хятад, Хойд Солонгосын хилд оршдог Пэгтү галт уул идэвхжиж дэлбэрч болзошгүй байгааг ч анхааруулж байна.

Халуун цөмийн гинжин урвалд

суурилсан устөрөгчийн бөмбөгийн туршилтыг анх АНУ 1952 оны 11 дүгээр сард Номхон далайн Маршаллын аралд, ЗХУ 1955 оны 11 дүгээр сард Казакстаны Семипалатинскийн районд, Их Британи 1957 оны 5 дугаар сард Номхон далайн Малден аралд, Хятад 1967 оны 6 дугаар сард Шиньжан-Уйгурын Лоб нуурын ойролцоо цөлд, Франц 1968 оны 8 дугаар сард Номхон далайн Полинезийн шүрэн арал дээр туршиж байсан байдаг. Зөвхөн АНУ-ын анхны устөрөгчийн бөмбөгийн туршилтын хүч 10.4 мегатон байсан нь Нагасакид хаясан атомын бөмбөгнөөс 400 дахин илүү хүчтэй байсан гэж мэдэгдэж байсан.

Уг нь бүр 1991 оны 9 дүгээр сард хүйтэн дайны төгсөл үед НҮБ-ын индрээс АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш Өмнөд Солонгост байрлуулсан тактикийн цөмийн зэвсгийн 100 гаруй нэгжийг нийтэд нь тус улсын нутаг дэвсгэрээс бүрмөсөн гаргах нэг талын энхийн санаачилга гаргаж, Өмнөд Солонгос санаачилгыг таатай хүлээн авч тухайн үеийн Ерөнхийлөгч Но Тэ-үү солонгосын хойгийг Цөмийн зэвсэггүй бүс болгох тухай Тунхаглалыг гаргаж байв. Түүнд цөмийн зэвсгийг боловсруулах, турших, үйлдвэрлэх, хадгалах,

байршуулах, хэрэглэх, ураныг баяжуулахгүй байх, цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах чиглэлд МАгАтЭ-тай хамтран ажиллахаар заасан. Улмаар 1991 оны 12 дугаар сарын 31-нд Солонгосын хойгийг Цөмийн зэвсэггүйжүүлэх БНСУ, БНАСАУ-ын Хамтарсан Тунхаглалд Сөүл хотноо Ерөнхий сайд нарын түвшинд гарын үсэг зурж, 1992 оны 2 дугаар сарын 19-нд хүчин төгөлдөр болсон. 1993 онд Team Spirit хамтарсан сургуулилтыг ч бүрэн зогсоосон. Гэвч юу ч өөрчлөгдөөгүй. 1995 онд Солонгосын хойгийн эрчим хүчний хөгжлийн байгууллага KEDO байгуулагдаж, эрчим хүчний гүн хямралд байсан Хойд Солонгосын зөвлөлтийн үеийн бал чулууны цөмийн реакторыг хөнгөн усны реактораар шинэчлэх ажил АНУ, Япон, БНСУ болон ЕХ-ны дэмжлэгтэйгээр эхэлсэн. Гэвч энэ ажил мөн л бүтэлгүйтсэн. Хойдуул 2003 онд үл дэлгэрүүлэх гэрээгээс дахин гарсан. 2007 онд зургаан талт хэлэлцээнээс гарч, 2009 онд МАгАтЭ-гийн шинжээчдийг нутгаасаа гаргасан. Үнэхээр байнга давтагдаж ирсэн *өдөөн хатгалга-хориг-яриа хэлэлцээ-буулт-тусламж* гэсэн *stereotype* үеэ нэгэнт өнгөрөөсөн.

Өмнөд Солонгос АНУ-тай хамтран Хойд Солонгосын

болзошгүй түрэмгийллээс хамгаалахын тулд хавар, намар “Fool Eagle”, “Key Resolve”, “Max Thunder”, “Ulchi - Freedom Guardian”, “Vigilant Ace Drill” хамтарсан цэргийн сургуулилт хийдэг.

ХОЙД СОЛОНГОСЫН ЦӨМИЙН БОЛОН ПУУЖИНГИЙН ТЕХНОЛОГИЙН ХӨГЖИЛД НӨЛӨӨСӨН ХҮЧИН ЗҮЙЛС:

Хойд Солонгосын Ёньбоны цөмийн судалгааны төвийн барилгын ажил зөвлөлтийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар 1965 оноос эхэлж 1974 онд 2 мВ-ын хүчин чадалтай судалгааны реакторыг ашиглалтад оруулж, 1979 онд 8 мВ-ын хоёрдахь реакторын ажил эхэлсэн байдаг. БНАСАУ Зөвлөлтийн Дубна дахь Цөмийн судалгааны нэгдсэн институтэд 1956 онд нэгдэж, мэргэжилтнээ бэлтгэж эхэлсэн байх бөгөөд 1970 оноос Хятадад бэлтгэж эхэлсэн. Хойд Солонгос зөвхөн 2013 онд 400 мянга, 2014 онд 470 мянга, 2015 онд 530 мянган ам. долларын татвар Дубна дахь Цөмийн нэгдсэн институтэд төлсөн байх юм. ЗХУ задарсны дараа Украин, Оросын хар зах дээрээс цөмийн болон пуужингийн технологи, мэргэжилтнүүд олж авсан бололтой байдаг.

САНХҮҮЖИЛТЫН ЭХ СУРВАЛЖ:

2008 оны 2 дугаар сард БНСУ-ын Ерөнхийлөгч Ий Мён-пак үүрэгт ажилдаа орсны дараа АНУ, БНСУ-ын тусгай албадын хамтран явуулсан эрчимтэй ажиллагааны үр дүнд гол нь оффшор бүс болох Макао, Лихтенштейн, Сингапур, Карибын тэнгисийн банкуудын 200 гаруй дансанд байршуулсан, эх сурвалж нь хууль бус замаар олсон 4 тэрбум ам.долларыг илрүүлсэн байдаг. Сүүлд АНУ-ын хоригт орсон Хойд Солонгосын



халхавч компани болох Daedong Credit Bank, түүний гүйцэтгэх захирал Ким Чол-сам, хамтрагч Британийн иргэн Negil Cowie нарын мэдээлэл 2016 оны 4 дүгээр сард Панамын баримт бичгүүдэд ил болсон. Хойд Солонгос 2000 онд Пёньянд зохиогдсон хоёр солонгосын анх удаагийн дээд уулзалтын болзолд Өмнөдөөс 400 сая ам. доллар авч тэр нь цөмийн хөтөлбөрт зориулагдсан хэрэг тодорхой болж 2005 онд ноцтой шуугиан дэгдэж байсан.

ХҮРЦАДМАЛ БАЙДЛААС ГАРАХ ГАРЦ:

Ким Жон-үн-ыг хэлэлцээний ширээнд суулгахад туслах нэг арга нь түүний хийж буй үйлдлийн үр дагаврыг түүнд тодорхой харуулах явдал гэж АНУ үздэг. Д.Трамп Хойд Солонгос дайтахыг “гуйгаад” байна, стратегийн тэвчээр барагдлаа гэсэн. БХ-ын сайд Жеймс Мэттис маш тодорхой хэлсэн: “том хохирол гарна, ганцхан зүйл өөрчлөгдөх нь тодорхой. Одоогийн дэглэм нуран унана” гэсэн байна. Саяхан Д.Трампын баталсан АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын шинэ стратегид Хойд Солонгосын

цөмийн болон пуужингийн аюулаас гадна кибер халдлагыг шинээр оруулав.

Одоогийн байдлыг ажихад хар ус ууж, хагд өвс идсэн ч цөмийн хөтөлбөрөөсөө ухрахгүй бололтой. Эхний ээлжинд Хойд Солонгос-АНУ хоёр vis-a-vis зарчмаар асуудлыг хэлэлцвэл энэ нь боломжтой гарц байх магадлалтай. БНХАУ, ОХУ хоёр АНУ, БНАСАУ шууд яриа хэлэлцээ явуулах, хамтарсан цэргийн сургуулилтаа зогсоохыг санал болгодог. АНУ энхийн гэрээ байгуулах, шууд яриа хэлэлцээ хийхийн тулд Пёньян эхлээд цөмийн хөтөлбөрөө бүрэн зогсоох шаардлага тавьдаг. ОХУ-ын зуучлах санал нэг их явахгүй.

Саяхан ХБНГУ-ын канцлерь А. Меркель 2015 онд Ирантай байгуулсан цөмийн хөтөлбөрийг нь царцаах P5+1 хэлэлцээрийн механизмыг санал болгосон нь анхаарч болох асуудал.

Хэрэв Хойд Солонгос Гуамд цохилт өгвөл Их Британийн Ерөнхий сайд Терезе Мэй саяхан Японд айлчлах үеэрээ мэдэгдэхдээ: АНУ НАТО-гийн гишүүн. Умард Атлантын гэрээний 5-р зүйлд “гишүүн оронд нь довтолбол гишүүн бүх оронд довтолсон

гэж үзнэ” гэсэн заалт хэрэгжиж, Атлантын-Номхон далайн зааг ялгаа байхгүйг тэмдэглэсэн.

2017 оны 11 дүгээр сард Сөүлд зохион байгуулагдсан “*Looking Ahead: Russia and Asia in the Next 20 Years*” сэдэвт “Валдай” олон улсын мэтгэлцээний клубын Азийн VIII бага хурлын нээлтэд БНСУ-ын Ерөнхийлөгчийн тусгай төлөөлөгч парламентын гишүүн Сон Ён-гиль хэлэхдээ: “ОХУ болон АНУ-ын харилцааны уур амьсгал сайжрах нь Солонгосын хойгийн хувьд нааштай дохио болох юм” гэсэн байна.

Лондонд БНАСАУ-ын ЭСЯ-нд элчин зөвлөхөөр ажиллаж байгаад 2016 оны 8 дугаар сард Өмнөд рүү дүрвэсэн дипломатч Тэ Ён-хо 2017 оны 11 дүгээр сард АНУ-ын Конгрессын Төлөөлөгчдийн танхимийн Гадаад хэргийн хороонд мэдээлэл хийхдээ: “Бид Хойд Солонгосын иргэдэд гадаад ертөнцийн тухай бодит мэдээллийг тараах замаар тэмцэх хэрэгтэй” Өөрөөр хэлбэл мэдээллийн дайн илүү үр дүнтэй.”, “АНУ энэ дэглэмийн эсрэг тэрбум тэрбумаар нь цэрэг зэвсэгт мөнгө зарж байна. Гэтэл Хойд Солонгос руу мэдээлэл цацахад жилд хэдийг зарж байгаа бол? Харамсалтай нь маш өчүүхэн хэмжээтэй гэдэгт би итгэлтэй байна” гэж зөвлөжээ.¹ Өөрөөр хэлбэл “зөөлөн хүч” ашиглахын чухлыг онцолсон байна.

Хойд Солонгосын зүгт зөөлөн хүчний бодлого явуулах нь маш чухал. Египетийн мэдээллийн технологийн компани Orascom Telecom Хойд Солонгост идэвхтэй үйл ажиллагаа явуулж, 2015 оны байдлаар 20-50 насны нийт иргэдийн 60 орчим хувь буюу 3 сая орчим хүн *Apple, Nokia, Samsung, Huawei* фирмийн 3G гар утас хэрэглэж байгаа ажээ. *Koryolink* нь Хойд Солонгосын гол оператор компани, 30 гаруй вэбсайт ажилладаг байна. Үүнийг ашиглан “*soft power*” бодлого явуулах нь

чухал юм. Мөн зах зээлд шилжих үйл явцыг алсаас, алгуур, үе шаттай дэмжих шаардлага буй.

ХОЁР СОЛОНГОС ИРЭЭДҮЙД НЭГДЭХ ТӨЛӨВ:

Судалгаагаар Өмнөдөд Хойдуултай энхтайвнаар нэгдэх хүсэлтэй иргэдийн тоо зогсолтгүй буурч тодруулбал, хойд нутагт төрсөн, ах дүү, садан төрлийн хэлхээ холбоотой бүхэл бүтэн үе нэгэнт дуусч байгаа ажээ. Өөрөөр хэлбэл тэдгээрийг нэгтгэж байсан гол хэлхээс үгүй болов. 2017 оны 9 дүгээр сарын эхээр явуулсан судалгаагаар өмнөдийн хүн амын 60 хувь нь цөмийн зэвсэгтэй болохыг дэмжсэн дүн гарсан байна. Эдүгээ хоёр Солонгосыг бүх талаараа хоёр өөр улс, үндэстэн гэж хэлж болно. Солонгосын нэгдлийг Германы нэгдэлтэй харьцуулшгүй. Ер нь нэгдэх үйл явцын яриа хэлцэл ХХI зууны туршид үргэлжилж магадгүй.

МОНГОЛ УЛСЫН БАЙР СУУРЬ:

Солонгосын хойгийн хурцадмал байдал Монгол Улсад шууд болон шууд бусаар нөлөөлөхөөр байдаг нь тодорхой билээ. Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлаж, цөмийн зэвсгээс ангид статусаа олон улсын тавцанд баталгаажуулах чиглэлээр загвар болохуйц туршлага хуримтлуусан боловч Хойд Солонгосын сүүлийн үед гаргаж буй цөмийн болон баллистик пуужингийн заналхийлэлд маш идэвхгүй байр суурь баримталж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Өөр нэг асуудал нь Монгол Улсын энхийн зууч хийх магадлал юм. 2014 оны 5 дугаар сард АНУ, БНАСАУ-ын төлөөлөгчид Улаанбаатар хотноо 2 дугаар сувгийн уулзалт хийж, БНАСАУ-ын цөмийн асуудлыг хэлэлцэж байсан билээ. Дурдсан уулзалтад БНАСАУ-ын Гадаад хэргийн дэд сайд бөгөөд зургаан талын

хэлэлцээний асуудал хариуцсан тусгай төлөөлөгч Ри Юн-хо (эдүгээ БНАСАУ-ын Гадаад хэргийн сайдаар ажиллаж буй) Зэвсэглэлийг хорогдуулах судалгааны хүрээлэнгийн зөвлөх гэсэн албан ёсны бус статустайгаар оролцож байсан юм. “Улаанбаатарын яриа хэлэлцээ” байна. Эдгээрийг үргэлжлүүлэх шаардлага, боломж буй.

2017 оны 11 дүгээр сарын эхээр БНСУ-ын Сөүл хотноо БНСУ-ы ГХЯ, НҮБ-ын *Peacebuilding Commission, Dag Hammarskjold foundation*-ын хамтран зохион байгуулсан “*The Asian Conference on Peacebuilding and Conflict Prevention*” сэдэвт олон улсын бага хуралд миний бие оролцсон юм. Энэ жил НҮБ-ын *Peacebuilding Commission*-ыг БНСУ даргалж байгаа юм байна. Энэ хурлын дараах өдрүүдэд БНСУ-ын ГХЯ-ны Солонгосын Үндэсний дипломатын академийн Гадаад бодлого, аюулгүй байдлын институттай хамтарсан уулзалт ярилцлага болж, дипломатын 1.5, 2 дугаар сувгийн “*Ulaanbaatar dialogue*”, Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого, Солонгосын хойгийн аюулгүй байдлын асуудал, хоёр талын харилцаа, тулгамдаж буй асуудлаар санал солилцов. БНСУ-ын Эв нэгдлийн яамны Солонгосын Үндэсний нэгдлийн институтийн удирдлагатай хамтарсан уулзалт болсон. Уулзалтаар Солонгосын хойгийн хурцадмал байдлыг энхийн замаар, дипломат арга хэрэгслээр шийдвэрлэх, түүнд Монгол Улс ямар үүрэг гүйцэтгэж болох, АНУ Хойд Солонгост зөөлөн хүчний бодлогоор хандах, Монгол Улс, БНАСАУ-ын харилцааны өнөөгийн байдал зэрэг асуудлаар санал солилцсон. Эндээс нэг зүйл ажиглагдсан нь өмнөд солонгосчууд Солонгосын хойгийн аюулгүй байдлын асуудлыг шийдэхэд Монгол Улс ямар ч байсан тодорхой үүрэг гүйцэтгэх боломжтой улс гэж үзэж байдаг нь баттай ойлгогдсон.

¹ Testimony of Minister Thae, Yong-ho House Committee on Foreign Affairs. November 1, 2017



Т.Заяа

Олон улсын эрх зүй судлаач

ӨӨРТӨӨ ЗАСАН ТОГТНОХ ЭРХ ҮҮ, СЕПАРАТИЗМ ҮҮ?

Салан тусгаарлах үзэл буюу сепаратизм нь өнөөгийн олон улсын харилцааны чухал асуудлуудын нэг болоод байна. Испани, Украин, Бельги, Итали болон бусад улсын засаг захиргааны нэгжүүд, бүрэлдэхүүн хэсгүүд эдгээр улсуудаас тусгаар тогтносноо тунхаглаж, шинэ статусаа дэлхийн хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрүүлэхээр ямар нэг алхам хийсээр байна.

Хоёр туйлт ертөнц үгүй болсоноор сепаратист хөдөлгөөнүүд дэлхийгээр тарж түгэн дэлгэрэх болсон байна. 1990-ээд онд дэлхийн улс төрийн газрын зураг дээр 26 бие даасан улс шинээр тэмдэглэгджээ. Зөвхөн ЗХУ, Югослав улс задарснаар 22 улс шинээр үүсэв. Дэлхийд төрт улс үүссэнээс хойш хоёр мянган жилийн түүхэнд төв рүү чиглэсэн бус харин төвөөс зугтсан хүч эрч хүчээ авч эхэлжээ. Олон улсын хамтын нийгэмлэг эдгээр шинэ улсыг тэр даруйд нь хүлээн зөвшөөрсөн нь магадгүй сепаратист хандлагыг



нэг ёсондоо өөгшүүлсэн хэрэг болсон байж мэднэ. Сепаратист хөдөлгөөний гол аюул нь зэвсэгт мөргөлдөөн, иргэний дайнд хүргэж, олон хүний амь насыг бүрэлгэдэгт оршдог. Чечений хоёр дайнд хамгийн багаар 200 мянган хүн амь эрсэдсэн байдаг. Косовод хичнээн хүн амиа алдсаныг одоог хүртэл тогтоогоогүй байна.

Дэлхийн нэгдүгээр дайны дараагаар өөртөө засан тогтнох

эрхийг ихэвчлэн үндэстэн угсаатнууд, харин дэлхийн хоёрдугаар дайны дараагаар колоний эзэмшилд байсан ард түмэн өөрсдийн тусгаар тогтнолыг олж авснаар албан ёсоор хүлээн зөвшөөрч байсан. Энэ нь тэр даруй л ноцтой асуудлыг бий болгосон. Тухайлбал, цаашид оршин тогтнох чадваргүй улсууд бий болж, үндэстэн хоорондын зөрчил мөргөлдөөн, сепаратизм,

дайн гарах нэг шалтгааныг бий болгожээ.

Бидний бодлоор 1919 оны Версалийн Гэрээ, 1945 оны НҮБ-ын Дүрэм зэрэг олон улсын харилцааны тулгуур гэрээ хэлэлцээрт тусгалаа олсон улс түмний өөртөө засан тогтнох эрх, нэг талаас, нөгөө талаас, сепаратизм хоёрын зааг ялгааг нарийн тогтоох шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, юуг өөртөө засан тогтнох эрх, юуг сепаратизм гэх вэ гэдгийг зааглана гэсэн үг юм. Энэ нь олон улсын эрх зүй, улс орнуудын дотоодын хууль тогтоомжтой холбогдох томоохон асуудлуудыг хөндөхөд хүргэх нь гарцаагүй. Нөгөөтэйгүүр, сепаратизмын тухай эрх зүйн цогц тодорхойлолт байхгүйгээс ихээхэн бэрхшээл учирдаг. Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)-аас 2001 онд баталсан конвенцид сепаратизмыг “нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд заналхийлсэн, түүний аль нэг хэсгийг салгах, салж бутрахад чиглэсэн хүчирхийллийн аливаа үйлдэл, мөн тухайн үйлдлийг хийхээр төлөвлөх, бэлтгэх, дэмжлэг үзүүлэх, өдөөн хатгах, сөргөлдөгч улсын хууль тогтоомжоор эрүүгийн гэмт хэрэгт тооцох аливаа үйлдлийг ойлгоно” хэмээн заасан байдаг.

Гэвч энэхүү тодохойлолт нь сепаратизмыг бүх утгаар нь тодорхойлсон хэрэг биш бөгөөд гол асуудал нь сөргөлдөгч талыг эрүүгийн хариуцлагад татах, мөн зөвхөн тус байгууллагын гишүүн улсуудад хамааралтай ойлголт юм.

Гэсэн хэдий ч сепаратизмын асуудлыг олон аргаар шийдвэрлэх боломжтой. Хамгийн тохиромжтой шийдвэрийг сонгохын тулд тухайн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, салан тусгаарлагчдын бодит тоо хэмжээ, тэд хэрэг дээрээ чухам юуг хүсэж байгааг судлаж мэдэх нь зүйтэй. Мөн түүнчлэн тухайн нөхцөл байдалд улсын зүгээс ямар буулт хийх боломжтойг олж тогтоохын тулд нийгмийн бусад гишүүд ямар санал бодолтой байгааг судлаж мэдвэл зохилтой.

Олон угсаатан үндэстнээс бүрдсэн үндэстэн улс –nation state, “Нэг ард түмэн – нэг улс” гэсэн гаргалгааг цаашид баримтлаж болохгүй гэдгийг НҮБ болон олон улсын бусад байгууллагууд ухааран сепаратизмыг эрх зүйн хувьд хязгаарлахыг оролдсоор ирсэн байдаг. Олон улсын байгууллагууд улс түмний өөртөө засан тогтнох эрхийг салан тусгаарлах хэлбэрээр

хэрэгжүүлэхийг дэмждэггүй бөгөөд ийм байр суурь нь сепаратист хөдөлгөөнийг хөхиүлэн дэмжихгүй байхад чиглэсэн байдаг. Үүнийг НҮБ-ын ЕНБД асан Бутрос Гали 1995 онд ОХУ-д хийсэн айлчлалынхаа үеэр мэдэгдсэн. НҮБ-аас орчин үед баримталж буй үзэл баримтлал нь угсаатан үндэстнүүдэд сепаратизмгүйгээр өөртөө засан тогтнох хангалттай боломжийг олгож байгаа. Салан тусгаарлах бус харин нутаг дэвсгэрийн хэлбэрээр автономит нэгж болох, үндэсний соёлын шинжийг агуулсан автономит эрхтэй болох, эсвэл улс гүрнүүд нийтээрээ ардчилсан хэлбэрийг сонгох (үндэсний цөөнхийн эрхийг хууль болон шүүхээр баталгаатай хамгаалах) зэрэг хамаарна. Үүнтэй адил зохицуулалтыг Европын Холбооны Аюулгүй байдал, хамтын ажиллагааны 1975 оны Хельсинкийн төгсгөлийн актад дурьдсан байдаг. Энэ баримт бичигт үндэстэн хоорондын зөрчил мөргөлдөөнийг аль ч улс, хэсэг бүлэг улс хүч хэрэглэхгүйгээр, аль нэгнийхээ дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүйгээр шийдвэрлэнэ гэж заасан байдаг билээ.

Үргэлжлэл бий

2018: A YEAR OF TENUOUS STABILITY

The year ahead promises to be a lively one, full of discrete conflicts and crises. Or so it would seem. Sure, the world is complex, and when we analyze it we tend to do so by breaking it down into its constituent parts – North America, South America, Europe, and so on. But studying these regions in isolation can obscure the bigger picture.

The world is interconnected, so our understanding of it must involve the bigger themes that bind its countries together. In identifying these themes, we can lay out the compulsions and constraints that shape the global system and drive major events. In other words, we can predict what will happen next.

The world is too rich to be reduced to a single theme, but if it could, the theme would be disintegration. In every major region, the systems that have been in place either since the end of World War II or since the collapse of the Soviet Union are beginning to fall apart. Faith in these systems was badly shaken by the global financial crisis in 2008 and, to a lesser extent, the collapse of oil prices in 2014. For nearly a decade, the leaders of these regions have tried to manage the political and economic fallout from these crises.

In 2017, a year of only tenuous stability, some of the symptoms of the recent crises began to subside while others grew worse. New symptoms emerged. 2017 was not a year in which the global system broke down, but neither was it a year in which leaders were able to solve the problems that called into question the systems that govern the global order. These problems continue to shape some of the

most important geopolitical issues in 2018 – namely, the future of Europe, China's rise and the new configuration of the Middle East.

EUROPE'S FRAGMENTATION

To say Europe, as a whole, is disintegrating is somewhat misleading. The integrity of the European Union, though, has been under duress since 2008, as has the rationale behind its creation – that monetary, regulatory and legislative integration could bridge the deep-seated differences that have historically divided the Continent. The global economic crisis of 2008 revealed structural divides within the bloc, and as its wealthier members refused to rescue its poorer members, the economic crisis morphed into a political crisis.

The financial crisis also aggravated the divide between the elites and the lower classes within EU member states, galvanizing domestic political forces that rejected the right of Brussels to govern. Since then, Britain has voted to leave the bloc, and euroskeptic parties have gained prominence on the mainland. Meanwhile, the EU has lost credibility with non-member states, particularly those of Central and Eastern Europe, which increasingly took advantage

of being on the outside looking in, free as they were to float their own currencies and tailor their own regulatory environments toward competitiveness. In other words, Europe entered an era in which sovereign states began once again to reassert their sovereignty.

These trends largely continued through 2017 as Europe's economy largely stagnated and as anti-EU forces on the right continued to rise. Technocrats in Brussels, meanwhile, were unable to reconcile the bloc's inherent internal contradictions.

And so it is that after nine years the EU still cannot function as it did pre-crisis. It is unable to make core decisions collectively, and now its defining features are regional and social tensions fueled by economic issues and different cultural values.

In 2018, we do not expect these trends to accelerate dramatically, nor do we expect to see such anything as profound as the Brexit. But neither will the trends reverse. Europe will instead focus on coping with its new reality. And if it cannot spark more economic growth, the status quo will be further tested.

CHINA'S WARY RISE

In China, disintegration has been a threat throughout history. But as in Europe, the threat has intensified

since 2008, when it became clear that China's economic rise was not unstoppable. The government is trapped between conflicting economic and political realities. It cannot sustain breakneck growth on a foundation of low-wage exports, but it does not yet have the middle class needed to boost domestic consumption to levels that would insulate it from downturns in distant consumer markets. The reforms required to put the economy on sound footing would be extremely painful, risking major job losses that would threaten the political standing of the Communist Party. China's leaders have tried to split the difference by keeping the economy humming with credit-driven growth while implementing only modest reform. But this has merely left the country with enormous debt bubbles and a looming housing crisis, and only slightly closer to addressing its underlying problems. The risks of instability remain.

Thus, in 2017, the Communist Party consolidated its grip over society under President Xi Jinping, who spent much of the year purging rivals, reining in wayward economic sectors and warning that China had entered a "new era" marked by slower growth. He has become China's most powerful leader perhaps since Mao Zedong – and the underlying driver of his power consolidation was the threat of disintegration. There was a sufficiently widespread belief among Chinese elites that reconciling the country's deep internal contradictions required a strongman at the helm. If political repercussions from China's post-2008 economic path are inevitable, then the only option is to try to contain the political fallout through authoritarian means, or so the thinking in Beijing goes.

The shortcomings of Xi's authoritarianism are inevitable, and signs of a backlash will begin to emerge in 2018. Xi is already seeking to take advantage of the new political environment and the window of stable growth to double down on painful reforms. But the reforms themselves, particularly reducing industry capacity and introducing measures to cool real estate markets, will slow China's growth, leading to job losses and discontent. Beijing will also attempt to streamline bloated industries by picking winners and losers. Some of the losers will have political clout and an axe to grind. Xi and his allies will respond forcefully to any signs of dissent. Xi is too powerful to be taken down in the near future, but the near future will be tumultuous anyway.

THE MIDDLE EAST

The Middle East has never been a picture of consistently strong and coherent political structures, but its recent woes are less a result of the 2008 financial crisis than others'. Still, economic problems, such as those stemming from the brief crash in oil prices after 2008 and the structural shift in oil markets in 2014,

have accentuated its political problems. Hence the Arab Spring, which helped to create the Islamic State and the vacuum of authority in Syria, Iraq and Yemen. Political pressure within such pivotal Middle Eastern states as Saudi Arabia, moreover, has aggravated regional rivalries – all while the U.S. tries to divest itself somewhat from the region.

In 2017, disintegration laid the groundwork for major changes in the region. The Islamic State's territorial ambitions in Syria and

Iraq have been quashed, reopening a vast vacuum of authority in the region. Saudi Arabia succumbed to a generational political crisis. The main beneficiary of both of these developments has been Iran. With its unmatched influence in Syria, Iraq and

Lebanon, Iran is uniquely positioned to fill the vacuum left by the Islamic State. And Tehran's historical rival, Saudi Arabia, is too weak and too internally occupied to decisively counter Iran – or to even maintain solidarity in the Gulf Cooperation Council. This will embolden Turkey and Israel to play a bigger part in shaping the coming geopolitical order.

CONCLUSION

Disintegration, of course, is not the only defining characteristic of 2018. Other, small themes will mark the world's regions too. In East Asia, for example, events will be driven increasingly by the emerging competition between China and Japan and by efforts of the region's heavyweights to adapt to a less pronounced U.S. presence – a dynamic that will become manifest no matter how the crisis on the Korean Peninsula unfolds.


In Europe, divisions between the eastern and western parts of the Continent will become more pronounced, as illustrated by growing competition between Germany and Poland.

In the Middle East, attention will be overwhelmingly focused on Iran, which sees a rare opportunity to cement an arc of influence spanning all the way to the Mediterranean. But each of these, in their own way, attest to much broader if more subtle processes underway. It's in these larger themes that we'll find the changes on the horizon.

ИРГЭДИЙН МЕДИА АШИГЛАДАГ ДУНДАЖ ХУГАЦАА /СҮҮЛИЙН 3 ЖИЛД/

Телевизэд зарцуулдаг минут 2015 онтой харьцуулахад энэ жил 50 минутаар нэмэгдсэн. Интернет сошиал медиад зарцуулах хугацаа жил бүр нэмэгдэж 2016 онд 281 минутыг интернет сошиал медиад зарцуулж байна. Харин бусад медиа хэрэгслүүдэд зарцуулж буй хугацаанд өөрчлөлт гараагүй байна. Фм радиод зарцуулах хугацаа нэмэгдэхгүй байгаа хэдий ч ТВ, интернет болон сошиал медиад зарцуулах хугацаа нэмэгдэхийн хирээр Фм радиод зарцуулах хугацааны эзлэх хувь багасч байна.

МИНУТ



	Эзлэх хувь /Нийт/		
	2014 он	2015 он	2016 он
Телевиз	42%	36%	35%
Фм	21%	37%	12%
Сонин	7%	15%	8%
Сэтгүүл	7%	10%	7%
Интернет, сошиал	23%	10%	38%

■ # Өмнөх оноос өссөн
■ # Өмнөх оноос буурсан

Жич:..Тухайн медиа хэрэгслүүдийг идэвхтэй ашигладаг хүмүүсийн хувьд

МЕДИА ХЭРЭГСЛҮҮДЭД
ЗАРЦУУЛДАГ ХУГАЦААНЫ
ӨСӨЛТ /2015-аас 2016 он/

АЖЛЫН ӨДӨР **↑122 минут** 25%
АЖЛЫН ӨДӨР **↑184 минут** 27%

НОМЫН ЕРТӨНЦӨӨР



Олон улсын эдийн засагч, зөвлөх профессор, доктор Б.Санжмятавын ээлжит бүтээл уншигч олны гарт хүрээд хэдхэн долоо хонож байна. “Дипломат болон бизнесийн олон улсын хэлэлцээ: онол, технологи, үйл явц, хэлэлцээ хийх үндэстний сэтгэлгээний онцлог, ёслол” хэмээх эл номыг МУИС-ийн ОУХНУС эрхлэн хэвлүүлжээ.

Яриа хэлцээ, хэлэлцээ нь улс хоорондын харилцааны гол хэрэгслийн хувьд төрөл бүрийн шугамаар, янз бүрийн түвшинд байнга явж байдаг бөгөөд түүний үр дүн, өгөөж нь хэлэлцээний арга ухааныг хэн, хэрхэн эзэмшинээс шууд шалтгаалдаг. Судлаачид хэлэлцээний арга ухааныг нэг талаас шинжлэх ухаан, нөгөө талаас урлаг гэж үздэг нь энэ ажиллагаа орчин үеийн олон улсын харилцаа, дипломат үйл ажиллагаанд ямар өндөр байр суурь эзэлж байдгийг бэлхнээ илтгэх буюу.

Зохлогч эл номондоо олон улсын дипломат болон бизнесийн хэлэлцээний ойлголт, тэдгээрийн арга, хэлбэр, үйл явцыг тал бүрээс нь нягтлан харуулахын зэрэгцээ хэлэлцээ хийхэд баримталдаг ёслол, үндэстний онцлог хүргэлх өргөн хүрээг хамарч, тодорхой түүхэн баримт, арвин практик жишээнд тулгуурлан өгүүлсэн нь олон улс судлаач, оюутан суралцагсдын төдийгүй гадаад харилцаа, бодлого сонирхогч хэн бүхний анхаарал, талархлыг зүй ёсоор хүлээнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

📍 Монгол улс, Улаанбаатар хот, СБД,
МУИС-ОУХНУС V байр 308 тоот

✉ thinktanks99@gmail.com

☎ 976 99070579

☎ 976-11354610

